

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Төслийн нэр	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч	4
2.3. Төслийн байршил	4
2.4. Уурхайн нөөц	5
2.5. Хүчин чадал	5
2.6. Уурхайн ажлын горим	5
2.7. Бутлан ангилах хэсгийн ажиллах горим, хүчин чадал	5
2.8. Уулын ажлын календарь төлөвлөлт	6
2.9. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт	6
2.10. Бутлан-ангилах хэсгийн технологийн горим	7
2.11. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо	8
2.12. Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт	8
2.13. Төслийн дэд бүтэц	9
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	11
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	14
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	17
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	22
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	29
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	30
ДҮГНЭЛТ	31
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол	4
Хүснэгт 3. Уулын ажлын календарь төлөвлөлт	6
Хүснэгт 4. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүд	6
Хүснэгт 5. Бутлан ангилах тоног төхөөрөмжүүд	7
Хүснэгт 6. Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ эхний 5 жилээр	8
Хүснэгт 7. Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ	8
Хүснэгт 8. Төслийн нийт ажилчдын тоо	8
Хүснэгт 9. Төслийн нийт усны хэрэглээ	10
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
Хүснэгт 16. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	29
Хүснэгт 17. 2024 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Эхэн” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг	5
Зураг 2. Барилгын чулуу бутлан-ангилах хэсгийн технологийн схем	8

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Эхэн” нэртэй барилгын чулууны орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Тус төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Шинэ зууны эхэн” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		1111010042
3	Уурхайн нэр		“Эхэн” нэртэй барилгын чулууны орд ашиглах төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Өмнөговь аймаг
5		Сум/Дүүрэг	Даланзадгад
6	Ашигт малтмалын төрөл		Барилгын чулуу
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		SGMV-00013
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Өмнөговь аймаг
9		Сум/Дүүрэг	Даланзадгад
10		Баг/Хороо	7-р баг
11	Захирлын хаяг	Нэр	Захирал Ж.Энхманлай
12		Гар утас	976-88885358

2.1. Төслийн нэр

“Эхэн” нэртэй барилгын чулууны ордыг ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Шинэ зууны эхэн” ХХК


2.3. Төслийн байршил

“Эхэн” нэртэй барилгын чулууны ордын талбай нь Улаанбаатар хотоос баруун урагшаа 580 км-т, Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос зүүн урагшаа 8 км-т байрладаг.

Нийт 261.1 га талбайтай.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	104	27	00	43	31	00
2	104	27	45	43	31	00
3	104	27	45	43	30	35
4	104	28	55	43	30	35
5	104	28	55	43	30	12
6	104	27	00	43	30	12



Зураг 1. “Эхэн” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг

2.4. Уурхайн нөөц

“Эхэн” нэртэй барилгын чулууны ордын батлагдсан геологийн нөөц В+С зэрэглэлээр 45,77 сая.тн үүнээс В зэрэглэлээр 22.2 сая.тн, С зэрэглэлээр 23.5 сая.тн байна. Ордын В нөөцийг бүрэн олборлох ба зайлшгүй байдлаар С нөөц өртөнө.

2.5. Хүчин чадал

Иймд тус уурхайн хүчин чадал, барилгын чулууныэрэлт хэрэгцээ зэргийг үндэслэн уурхайн хүчин чадлыг жилд 25.0 мян.м³ барилгын чулуу олборлохоор байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний эхний 5 жилийг жил бүрээр дараагийн жилүүдийг 10, 20, 30 жилийн эцсийн байдал, мөн ордын В зэргийн нөөцийг бүрэн олборлох уурхайн эцсийн хүрээг гаргасан болно.

2.6. Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 180 хоног ажиллах бөгөөд тухайн ажиллах хугацаан дахь Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын нөхцлөөс хамаарсан түр зогсолт болон улирлын чанартай сул зогсолт хийх зэрэг хүчин зүйлсийг тооцон уурхайг 180 хоног ажиллана гэж төсөлд тусгалаа.

2.7. Бутлан ангилах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

“Эхэн” ордын дайрга боловсруулах хэсэг нь ил уурхайн үйл ажиллагаа хүйтний улирлын уялдаа холбоотойгоор 4 сараас 10 сар дуустал ажиллах бөгөөд уурхай ажиллах хугацаанд тохиох Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрахбаяр ёслолын хоногууд болон цаг агаараас саатах зэргийг тооцон бодит ажиллах 180 хоног гэж төсөлд тусгалаа.

Бутлан ангилах хэсгийн жилийн хүчин чадал 25,000 м³ дайрга бутлан ангилах хүчин чадалтай байна. Барилгын чулуу нь дундажаар 2.6 гр/см³ нягттай.

2.8. Уулын ажлын календарь төлөвлөлт

Уурхайн ашиглалт нь В-V блокийн зүүн хойд хэсгээс эхлэн баруун хойшоо чиглэлтэй явагдах бөгөөд эхний 10 жилд В-V блокоос олборлолт хийж, цаашид В-VI блокоос олборлолт явагдана.

Хүснэгт 3. Уулын ажлын календарь төлөвлөлт

Ашиглалт- ын жил	Барилгын чулуу			
	м ³	тн	Өссөн дүнгээр, м ³	Өссөн дүнгээр, тн
1	24,587	63,925	24,587	63,925
2	25,150	65,389	49,736	129,314
3	24,408	63,461	74,144	192,776
4	26,193	68,102	100,337	260,877
5	25,501	66,303	125,839	327,180
6	25,038	65,098	150,876	392,278
7	25,038	65,098	175,914	457,375
8	25,038	65,098	200,951	522,473
9	25,038	65,098	225,989	587,570
10	25,038	65,098	251,026	652,668
11.-20	497,411	1,293,268	748,437	1,945,936
21.-30	750,857	1,952,228	1,499,294	3,898,164
100	25,000	65,000	2500000	6,500,000
200	25,000	65,000	5000000	13,000,000
300	25,000	65,000	7500000	19,500,000
390	25,000	65,000	9,775,563	25,416,464

2.9. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 4. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүд


Д/д	Тоног төхөөрөмж	Марк	Хүчин чадал	Тоо, ш
1	Өрмийн машин	SUNWARD SWDN 89-1		1
2	Экскаватор	HYUNDAI HX160L	0.5 м ³	1
3	Автосамосвал	HOWO siac	10 тн	2
4	Утгуурт ачигч	Luigong ZL50	3 м ³	1

Хүснэгт 5.Бутлан ангилах тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмж	Тоо, ш	Марк	Хүчин чадал	Цахилгаан зарцуулалт, квт/цаг
1	Чичиргээт тэжээгүүр	1	GZD850	70-100 тн/ц	4.4
2	Хацарт бутлуур	1	PE-500*750	50-100 тн/ц	45
3	Конусан бутлуур	1	PYB900	50-90 тн/ц	55
4	Чичиргээт шигшүүр	1	ЗҮК1237	30-100 тн/ц	15
6	Туузан дамжуулагч – 1	1	B500*15M	40 тн/ц	5.5
7	Туузан дамжуулагч – 2	1	B500*18M	90 тн/ц	7.5
8	Туузан дамжуулагч – 3	1	B500*20M	90 тн/ц	7.5
9	Туузан дамжуулагч – 4	1	B500*16M	40 тн/ц	5.5
10	Туузан дамжуулагч – 5	1	B500*16M	40 тн/ц	5.5
11	Туузан дамжуулагч – 6	1	B500*16M	40 тн/ц	5.5
12	Туузан дамжуулагч – 7	1	B500*16M	30 тн/ц	5.5
13	Тоос барих тоног төхөөрөмж	2	QD36	2100м ³ /цаг	4

2.10.Бутлан-ангилах хэсгийн технологийн горим

Барилгын чулууг олборлон бутлаж ангилан эцсийн бүтээгдэхүүн -20+10мм, -10+5мм, -5мм ширхэглэлтэй дайрга боловсруулан гаргана. Дайргыг барилгын хүнд бетон үйлдвэрлэхэд түүхий эд болгон ашиглах, мөн нарийн ширхэгтэйг нь дүүргэгч материалд ашиглахад тохиромжтой. Стандартын шаардлага хангасан дайрга үйлдвэрлэхийн тулд бутлан ангилах технологийг оновчтой өртөг зардал багатай найдвартай ажиллагааг хангасан байх шаардлагатай.



Зураг 2. Барилгын чулуу бутлан-ангилах хэсгийн технологийн схем

2.11. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Хүснэгт 6. Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ эхний 5 жилээр

Үзүүлэлт	Ашиглалтын жил				
	1	2	3	4	5
Бутлан ангилалт	24,587	25,150	24,408	26,193	25,501
Хаягдал	1156	1182	1147	1231	1199
-20+10мм-н ширхэглэлтэй	8,576	8,772	8,513	9,136	8,895
-10+5мм-н ширхэглэлтэй	11,317	11,577	11,235	12,057	11,738
-5мм-н ширхэглэлтэй	3,538	3,619	3,512	3,769	3,670

Хүснэгт 7. Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ

Үзүүлэлт	Ашиглалтын жил		
	6-10	11-20	21-30
Бутлан ангилалт	125,187	246,384	253,446
-20+10мм-н ширхэглэлтэй	43665	85938	88401
-10+5мм-н ширхэглэлтэй	57623	113410	116661
-5мм-н ширхэглэлтэй	18015	35455	36472

2.12. Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт

Хүснэгт 8. Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	Ажилчдын орон тоо
1	Төв оффис	3
2	Уулын хэсэг	7
3	Бутлан ангилах хэсэг	2

4	Засвар механикийн хэсэг	2
5	Аж ахуй, үйлчилгээний хэсэг	4
	Нийт	18

2.13.Төслийн дэд бүтэц

Барилга байгууламж:

Үйлдвэрлэлийн барилга байгууламжид дараах барилга байгууламжууд хамаарна.

- Шатахуун түгээгүүрийн байгууламж,
- Авто засварын газар,
- Сэлбэг хэрэгслийн агуулах,
- Хамгаалалтын хашаа, пост.

Уурхайн ахуйн хэрэглээний барилга байгууламжид дараах барилга байгууламжууд хамаарагдана.

- Уурхайн захиргааны байр
- Хоолны газар
- Ажиллагсдын амрах байр
- Халуун ус.

Цахилгаан хангамж:

“Эхэн” барилгын чулууны орд нь Даланзадгад сумаас 5 км зайтай байрладаг. Тус уурхайн цахилгаан хангамжийг Даланзадгад дэд станцаас авах боломжтой бөгөөд 6кВ-н хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар 4 км зайд татаж 6/0.4кВ-ийн трансформатораар бууруулж авна. “Эхэн” барилгын чулууны ордын цахилгааны гол хэрэглэгчид нь бутлан ангилах хэсэг, засварын цех, кэмп зэрэг болно. Ил уурхайд цахилгааны хэрэгцээ байхгүй. Уурхайн дээрх бүх цахилгаан хэрэглэгчдийн тооцооны бүрэн чадал нь тооцоогоор 175 кВа гарсан байна.

Усан хангамж:

Барилгын чулуу олборлолтын хугацаанд технологийн ус ашиглахгүй, уурхайн нөхөн сэргээлтийг хаалтын үе шатанд хийх бөгөөд нөхөн сэргээлтэнд ус ашиглахгүй байна. Харин унд, ахуй болон зам арчилгаа, ногоон байгууламжинд зориулалтаар ус ашиглана.

Уурхайн усны эх үүсвэрийг уурхайн талбайгаас 8.8 км-ийн зайд орших “Гэгээ автосервис” ХХК-ийн эзэмшлийн гүний худгаас гэрээгээр хангахаар байна.

Хүснэгт 9. Төслийн нийт усны хэрэглээ

№	Усны хэрэглээ	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он	Нийт усны хэрэглээ, м ³	Шаардлагатай усны ундрага, л/с
1	Унд ахуйн усны хэрэглээ	м ³	459	459	459	459	459	2,295	0.147
2	Замын усалгаа	м ³	54	58.8	60.6	61.8	64.2	299.4	0.086
3	Ногоон байгууламжийн усалгаа	м ³	480	480	480	480	480	2,400.0	0.868
	Нийт	м³	993	997.8	999.6	1,000.8	1,003.2	4,994.4	1.102

5 жилийн хугацаанд нийт 4,994.4 м³ ус ашиглахаар байна. Нийт 1.1 л/с усны ундрага шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй:

Физик газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Талбай орчимд баруун хойноосоо зүүн урагш сунаж тогтсон Говь-Алтайн уулсын төгсгөл хэсэг болох Гурван сайханы нурууны зүүн Сайханы зүүн үзүүр хамаарна. Дээрхи уул нурууд нь сайр, жалгаар хэрчигдсэн голчлон налуу хажуутай бөгөөд өргөрөгийн дагуу сунаж тогтсон хоолой, хөндийгөөр тусгаарлагдсан нам уулсын гадаргуу зонхилно. Талбай нь аймгийн төвийн зүүн урд Холбоо толгой орчимд байрлана.

Геоморфологи:

Барилгын чулууны ордын талбай нь физик газарзүйн ангиллаар говь хээрийн мужид хамрагдах цөлөрхөг говь хээрийн бүс юм. Хэрчигдэл ихтэй Гурвансайханы нурууны салбар дунд зэргийн өндөр уулс түүний үргэлжлэл бөөнөөр цуварч тогтсон толгодлог нам уулс элбэгтэй бөгөөд уулс хооронд тэгш тал, хөндийгөөр алслагдсан бэсрэг уулс, гүн биш янз бүрийн хэлбэртэй, Ү маягийн хуурай сайр, жалга, судгаар хэрчигдсэн долгиолог тал үргэлжилнэ. Иймд газрын гадаргуугийн хэв шинжийг дараах байдлаар ялгав. Үүнд: Тектоник-элэгдлийн, идэгдэл-хуримтлалын, хуримтлалын гэсэн 3 гадаргуу болно.

Цаг агаар:

Даланзадгад орчимд жилийн дундаж агаарын температур +4,0 ба бусад аймгуудаас дулаан, хамгийн дулаан нь 7 сард +21 градус, хамгийн хүйтэн нь 1 сард -15,4 градус, тогтвортой хүйтэн байх хугацаа жилд 140 хоног буюу 10-р сарын 2-ноос дараа жилийн 3-р сарын 22 хүртэл үргэлжилнэ. Салхины чиглэл ихэвчлэн баруун ба баруун хойноос, дундаж хурд 4-5 м/сек. Хүчтэй салхитай хоногийн тоо жилдээ дунджаар 45 хоног байх бөгөөд салхитай өдрүүдийн олонхи нь 3,4,5-р саруудад тохионо. Хөрсний гадаргуу дээрх цочир хүйтрэх анхны хугацаа 9-р сарын 16, сүүлчийнх нь 5-р сарын 22 байдаг. Жилдээ 129 мм тунадас орох ба ихэнх нь 4-10-р сард унана. Тогтвортой цасан бүрхүүл тогтох хугацаа 41 хоног буюу 12-р сарын 9-нөөс дараа жилийн 2-р сарын 13 хүртэл байх ба 3-р сарын сүүлээр цас үндсэндээ хайлж дуусдаг.

Усан орчин:

Энэ бүс нутаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд, гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй мужийн Өмнөговь аймгийн дүүрэг, Алтайн уулархаг атираат мужид хамаарна. Уг талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, унах хур тунадасны хэмжээ бага, ууршилт ихтэй, байнгын урсацтай гадаргын ус байхгүй. Усан сүлжээ уулсын хэлбэршлээ дагаад сайн хөгжсөн 1-50м хүртэл өргөнтэй түр зуурын урсгал усны хуурай сайр элбэгтэй ч энэ нь зөвхөн бороо, хур ихтэй үед үерлэн урсгалтай болж уулс хоорондын хотгор руу урсац үүсгэнэ.

Ордын дүүргийн талбайд байгаа түр зуурын урсгал усны сайр, гуу жалга нь зүүн хойш чиглэлтэй юм. Талбайн ойр орчимд хур бороо ихтэй үед сэргэдэг булаг шанд, унд ахуйн хэрэглээний усны хэрэгцээг хангадаг гар худгууд тэмдэглэгдсэн байдаг. Манай тусгай зөвшөөрөлтэй “Бор тээг” талбайд ямар нэгэн булаг шанд, өрөмдмөл худаг байдаггүй бөгөөд талбайн гадна талд Холбоо худаг, Бага булаг гэх мэт 3 булаг, 2 худаг тэмдэглэгдсэн байна.

Уурхайн усны эх үүсвэрийг уурхайн талбайгаас 8.8 км-ийн зайд орших “Гэгээ автосервис” ХХК-ийн эзэмшлийн гүний худгаас гэрээгээр хангахаар байна.

Хөрсөн бүрхэвч:

Төслийн талбай нь хөрс газар зүйн мужлалаар Говийн хөрсний цөлөрхөг хээрийн бүсэд хамаарна. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс, ургамал тачир сийрэг учраас хөрсний бүрхэвчийн бүтцийн хувьд хөрсний элэгдэл-хуримтлалын чулуурхаг нимгэн ба гүйцэд хөгжилтэй хөрс, элэгдлийн ил гарсан хад чулуу бүхий дутуу ба гүйцэд хөгжилтэй хөрс, хуримтлалын мараалаг ба марзлаг хөрс, үлээгдэл хийсэлтийн цөлийн гөлтгөнөтэй бор саарал хөрс, хөрсний бус зүйл элс тархсан.

Тус төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий тэгшивтэр талд байрлаж байна. Энд харьцангуй өндрөөрөө 30-40 метр ухаа гүвээнүүд, тэдгээрийн хооронд орших тэгшивтэр талуудтай бөгөөд үнэмлэхүй дундаж өндөр нь д.т.д 1100-1500 м. Толгодын өвөр болон ар хажуугийн дээд хэсгээр хатуу суурь чулуулаг газрын гадаргад ойр орших бөгөөд чулуурхаг хөрсөнд ургадаг хуурай хээрийн ургамалшил дор сул хөгжилтэй сайр чулуурхаг цөлөрхөг хээрийн бор хөрс тогтворжсон. Түүнээс доош толгодын хажуу руу намсаж бэл рүүгээ дөхөх тусам нунтаг шороон хурдасны зузаан нэмэгдэж цөлөрхөг хээрийн сайр чулуун хучаастай говийн бор хөрстэй болж ирнэ. Толгодын хоорондын хотос хонхороор дэрс, харгана голлосон үетэнт алаг өвст хээрийн ургамалшил дор мараа хэлбэрийн хөрс тархсан. Төслийн талбайд нам уул ухаа толгод болон тал газар, хөндийн хотгорын хөрс тархана.

Ургамлан нөмрөг:

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалтаар хувьд Евразийн хээрийн их муж, Дорнод говийн цөлийн хээрийн дэд мужид хамаарна. Судалгааны талбайн нь 17 овгийн 43 төрлийн нийт 48 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг 8, олон наст өвс 25, ганц ба хоёр наст 15 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Судалгааны талбайн эргэн тойронд ургамал нөмрөгт өөрчлөлт орсон. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь сор1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй байна. Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг сөөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингын сөөг, сөөгөнцөр ургамал дээд дэд, олон наст өвслөг, ургамал дунд дээд, өнгөрсөн жилийн борог өвс, хагд (найлзуурууд) доод дэд ташингийг бүрдүүлж байна.

Амьтан:

Тус лицензийн талбайн нь амьтны газарзүйн мужлалаар (Банников, 1954; Батчулуун, 2020) Монгол Түвдийн мужийн, Говийн дэд муж, Хойт говийн тойрогт хамаарна. Харин байгалийн бүсийн хувьд цөлийн бүсэд тооцогдоно (Даш, 2016).

Даланзадгад орчмын нутаг дэвсгэрт хөхтөн, шувуу, мөлхөгчдийн гэх 3 ангид хамаарах 42 зүйлийн сээртэн амьтад бүртгэгдсэн байна. Үүнээс 4 баг, 6 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйлийн хөхтөн, 16 зүйл шувуу, 8 зүйл мөлхөгчид тархдаг.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Төслийн талбай орших Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 580 км-т Даланбулаг нэртэй газарт байрлах ба, хүн амын суурьшил ихтэй, дэд бүтэц сайтай. 23298 суурин хүн амтай 476 км² нутагтай зам тээвэр, харилцаа холбоо сайн хөгжсөн, засаг захиргааны анхан шатны 8 нэгж, 64 төрийн байгууллага, 6 жуулчны бааз, арилжааны банкны 8 салбар, үүрэн телефоны 5 оператор, 10 уул уурхайн компанийн төлөөлөгчийн газар, орон нутгийн чанартай нисэх зурвас зэрэг нэг дор төвлөрсөн томоохон суурин газар юм. Нутгийн оршин суугчдын ихэнхийг халх ястан эзлэх ба уул уурхайн томоохон ордуудтай тул ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор манай Монгол орны бүх үндэстэн, ястангууд ирж суурьшиж байна. Эдийн засгийн төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн дүүрэгт харъяалагдана. Эхэн барилгын дайрга чулууны орд нь Даланзадгад хотоос зүүн урагш 7км зайнд Номгон сумыг холбосон шороон зам дагуу оршдог онцлогтой юм. Нэвтрэлтийн зэрэглэл сайн учир жилийн аль ч улиралд шороон замаар аль ч хэсэгт саадгүй зорчих бололцоотой.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Барилгын чулуу олборлолтын явцад нийт 12.4 га талбай эвдрэлд өртөнө,
- Олборлолтын явцад тоосжилт үүсэх, хөрс элэгдэл эвдрэлд орох, ургамлан нөмрөг талхагдах зэргээр газрын гадаргад өөрчлөлт орно,
- Олборлолтын явцад хоосон ухаш, овоолго нэмэгдэн үүсэж газрын хэвлий эвдэгдэх,
- Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл техникээс үүдэн газрын гадаргад өөрчлөлт орох,
- Овоолго үүсэх үед элс буулгах, ачих тээвэрлэх, уруу газар ачих зэрэгт байнгын тоосжилт үүсэх ба энэ нь гадаргад бохирдол үүсгэж болзошгүй,
- Уурхайн олборлолтоос үүссэн карьерийн нүхэнд хүн, мал, амьтад унах бэртэх сөрөг нөлөөтэй.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээвэрлэлт, олборлолтын үед үүсэх тоосжилт,
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээний нөлөөлөл,
- Уурхайн олборлолтын явцад хөрс хуулалт, хүнд механизмуудын ашиглалт зэргээс үүдэн агаарт дэгдэх тоосжилтын хэмжээ ихсэх, ойр орчмын газарт бохирдсон агаар тархах,
- Үүссэн тоосжилт, хорт хийн хэмжээ нь талбай дахь ажлын нөхцлийг муутгах улмаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх,
- Уурхайн үйл ажиллагааны явцад бутлуурын хэсгээс үүсэх тоосжилт,
- Уурхайд ашиглагдах тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарсан хорт утаа орчны агаарын чанарыг муутгах, Шаталтын үйл явцын дүнд СО (нүүрстөрөгчийн дутуу исэл), НС (нүүрс ус), NO_x (нитрат, нитрит), SO₂ (хүхрийн оксид) болон тоосжилт ялгарч агаарын чанарт муугаар нөлөөлөх,
- Төслийн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт, хорт хий газарт бууж ургамлан бүрхэвч ба хөрсөнд нөлөөлөх,
- Хог хаягдлаас үүсэх эвгүй үнэр ордын агаарын орчныг бохирдуулна.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Уурхай орчимд гадаргын ус байхгүй, гүний худаг байхгүй учраас усан орчинд үүсэх сөрөг нөлөөлөл бараг байхгүй байна,
- Уурхайн технологийн үйл ажиллагаанд ус ашиглахгүй, унд ахуй, зам усалгаа, ногоон байгууламжинд усыг зөөврөөр ашиглах учраас усанд үүсэх нөлөөлөл бага байна,
- Зөөврийн усыг зориулалтын саванд хадгалаагүйгээс ундны усны чанар муудах,
- Ахуйн бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх,
- Уурхайн эргэн тойронд үер усны аюулаас үүсэх нөлөөлөл.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Олборлолтын явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөх,
- Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах,
- Тээвэрлэлтийн нөлөөгөөр олон салаа зам үүсэх, хөрс элэгдэл эвдрэлд өртөх,
- Барилга байгууламж байгуулах явцад хөрс элэгдэл эвдрэлд өртөх,
- Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах,
- Хог хаягдал уурхайн орчинд тархаснаас үүдэн орчин бохирдох.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны явцад ургамлан нөмрөг талхлагдах, устаж үгүй болох,
- Уурхайн үйл ажилаагаанаас үүдэн олон салаа зам үүсч, тээвэрлэлт, олборлолтын нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах,
- Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслийн нөлөөгөөр тоосжилт үүссэнээс ургамал ба ургамлын бүрхэвч тоосонд дарагдаж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно,
- Уурхайд барилга байгууламж барих зэргээс газрын ургамал бүрмөсөн устана,
- Байгууламжууд баригдах талбай нь төслийн хугацаанд хүний хөлөөр болон тээврийн хэрэгслээр талхлагдаж бүрэн өөрчлөлтөнд орно,
- Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол үүснэ.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго хийх, барилга байгууламж барих, техник хэрэгсэл явах зам тавих, кемп барьсны улмаас эдгээр үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болох,
- Олборлолтоос, тээврийн хэрэгслийн дуу чимээнээс үүдэн мал амьтан үргэн дайжих,
- Уурхайн ухаш хоосон орон зайд мал амьтан унаж, бэртэх,
- Хууль бус ан агнуур хийх.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Технологийн үйл ажиллагаанаас үүсэх тооны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушиг болон амьсгалын замын эрхтэнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болно. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажиллассанаас ажилчдын анхаарал

сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа түр буюу бүрмөсөн алдах зэргээр осол аюул үүсэх,

- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүсэх,
- Уурхайн ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй,
- Уг төсөл хэрэгжих явцад ажлын байрны тоо нэмэгдсэнээр нийгэм эдийн засгийн хөгжилд хэмжээний эерэг нөлөөлөл үзүүлнэ,
- Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах эерэг нөлөөлөл үүснэ.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Шинэ зууны эхэн” ХХК-ийн “Эхэн” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Эхэн” нэртэй барилгын чулууны ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Шинэ зууны эхэн” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 11,416.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Эхэн” нэртэй барилгын чулууны ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Эхэн” нэртэй барилгын чулууны ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Тоосжилтын эх үүсвэрүүд: -Эвдэрсэн газар, тээврийн зам талбай, -Бутлуур шигшүүр, техник хэрэгслийн ялгарлаас, -Хог хаягдлыг зайлуулаагүйгээс.	Барилгын чулуу олборлолтын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж зам талбайд тогтмол усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Уурхайн талбай, тээвэрлэлт-ийн зам	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Тогтмол	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох, -MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
2		Тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд оношлогоо, засвар үйлчилгээг тогтмол хийх, техникийн үзлэгт оруулах.	Тээврийн хэрэгсэл	-	50,000	5	250,000	Жил бүр	
3		Хог хаягдлын цэг болон бие засах газар түүний ойр орчимд тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байх	Бие засах газар	-	-	-	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан	Улиралд 1 удаа	

Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	-Уурхайн үйл ажиллагааны улмаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсээс үүдэн хөрс элэгдэл эвдрэлд өртөх, -Хог хаягдлаас үүдэн орчин бохирдох, -ШТМ асгарч газрын гадарга хөрсийг бохирдуулах,	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах	Шимт хөрсний овоолго	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Уурхайн үйл ажиллагаа -ны эхэн үед	-MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, - MNS 3310- 91, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдахшаардлага, - MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
2		Шимт хөрсний овоолгыг салхинд тархахаас сэргийлж хамгаалах, ургамалжуулах		-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Жил бүр	
3		Тээврийн хэрэгслийг тогтсон нэг замын маршрутаар явуулах	Тээврийн хэрэгсэл	-	-	-	-	Тогтмол	
4		Уурхайн гадаад, дотоод тээврийг зориулалтын замаар зорчуулах, олон салаа зам гарахаас сэргийлэх, тэмдэг тэмдэгжүүлэх	Тээвэрлэлт-ийн замд таних тэмдэг	-	-	-	300,000	Жил бүр сайжруулах	
5		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах, бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж шинэ хөрсөөр сэлбэх	Зам талбай	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Тогтмол	
6		Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, орчны цэвэрлэгээг хийх	Хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	

Усан орчин									
1	-Ундны усыг зориулалтын саванд хадгалаагүй-гээс ус бохирдох, хүний биед муугаар нөлөөлөх, -Бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх.	Зөөврийн усыг зориулалтын ус нөөцлөх саванд хуримтлуулах, ус алдагдахаас сэргийлэх.	Ундны ус нөөцлөх сав	-	-	2	200,000	2024 онд	-Усны тухай хууль, -MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж, -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
2		Бохир ус хуримтлуулах цэгийг байгуулах, бохир усыг тогтмол хугацаанд зөөвөрлөн соруулах, ариутгал хийж байх	Бохир ус	-	-	-	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан	Улирал бүр	
		Нийт зардал					750,000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уурхайг эхний байдлаар 10 жил ашиглахаар ТЭЗҮ-д тусгагдсан бөгөөд уурхайн нөхөн сэргээлтийг уурхайн хаалтын үе шатанд хийхээр ТЭЗҮ-д төлөвлөсөн байна. Иймээс тухайн техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсаны дагуу нөхөн сэргээлт хийгдэхгүй.

6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх	Сумын засаг даргаас санал авсны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах ажлыг хийх.	Орон нутагт	-	-	5,000,000	2024 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага,

2		Говь гурван сайхан БЦГ-тай хамтарч ажиллах, санал хүсэлтийн дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, Говь гурван сайхан БЦГазар нутагт байрших амьтдад өвс тэжээл тавьж өгөх.						-БОНБНУ-ий тухай хууль.
3	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Мод тарих газар, тоо хэмжээг орон нутгаас санал авах	50ш	-	-	1,000,000	Жил бүр	
Нийт зардал						6,000,000		

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

“Эхэн” нэртэй барилгын чулууны ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй.

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Болзошгүй аюул, осол, саатал, техник	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	-	-	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт

**Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” нэртэй
барилгын чулууны ордыг ашиглах төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2024

2	технологийн шугам сүлжээний гэмтэл, -Галын гэнэтийн аюул үүсэх, -Ажилчид	Аваар устгах төлөвлөгөөг жил бүр батлуулж түүний дагуу ажиллах, ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч байх	Ажилчдад	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009
3		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайн кемп орчимд	-	-	500,000	Жил бүр	Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
4	бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх,	Ажиллагсдыг хөдөлмөр хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангах	Ажилчдад	17	80,000	1,360,000	Жил бүр	
5		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах, болзошгүй осол аваар гарахаас сэргийлэх арга хэмжээ авах	Ажилчдад	-	-	300,000	Жил бүр	-Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал.Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд,
6		Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ажилчдад	-	-	-	Тогтмол	
Нийт зардал						2,160,000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2024 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу хог хаягдал	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, салхинд тархахаас сэргийлэх,	Хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/,

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” нэртэй
барилгын чулууны ордыг ашиглах төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2024

		орчны цэвэрлэгээг тогтмол хийж байх							-MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, -Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, -Ариун цэврийн тухай хууль.
2		Кемп орчимд хог хаягдлын зориулалтын сав байрлуулах	Хогийн сав	-	100,000	2	200,000	2024 онд	
3		Хогийг тусгай нэг цэгт төвлөрүүлэх, салхинд тархахаас сэргийлж хашаажуулах	Хог хаягдлын цэг	-	-	-	300,000	2024 онд	
4		Хог хаягдлыг тухай бүрт ангилан ялгаж зарим боловсруулах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах	Хог хаягдал	-	-	-	-	Сар бүр	
5		Сумын засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулж, тухай бүрт тээвэрлүүлэх.	Хог хаягдал	-	-	-	350,000	Жилд 1 удаа	
6	Аюултай хог хаягдал	Уурхайгаас гарсан ашигласан шатах тослох материалын үлдэгдэл, аюултай хог хаягдлыг зориулалтын /хаяг шошго, битүүмжлэлтэй/ саванд хадгалах, хуримтлуулах, газрын гадаргад асгарч алдагдахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах	ШТМ хадгалах сав, поошик	ш	100,000	1	100,000	2024 онд	

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” нэртэй
барилгын чулууны ордыг ашиглах төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2024

7		Аюултай хог хаягдал, ашигласан шатах тослох материалын үлдэгдлийг аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлүү тээвэрлүүлэх	ШТМ	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд
8	Шингэн хаягдал	Стандартын шаардлага хангасан бие засах газар эко жорлон барих	-	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд
9		Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх, ахуйн бохир усыг цэвэршүүлж, ногоон байгууламж, зам усалгаанд ашиглах	Ахуйн бохир ус	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Судлах
10		Бие засах газарт болон бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Бие засах газар	-	-		200,000	Улирал бүр
Нийт зардал							1,150,000	

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Шинэ зууны эхэн” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2024 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ	-Ил уурхай, -Тээвэрлэлтийн зам,	Жилд 1 удаа 3 цэг	Шинжээчийн зардал -100,000	190,000	Аймгийн цаг уур орчны	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” нэртэй
барилгын чулууны ордыг ашиглах төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2024

	мэргэжлийн байгууллагаар хийлгэх	-Овоолго	3 сорьц дээж	Агаарын сорьц дээж 30,000		шинжилгээний харъяа лаборатори	-MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга, -MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга
Хөрсөн бүрхэвч							
1	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P ₂ O ₅ , K ₂ O, хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүн	-Ил уурхай, -Кемп орчим, -Овоолго -Тээвэрлэлтийн зам	Жилд 2 удаа	25,000	150,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
2	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Уурхай орчмоос бохирдсон байж болох цэгүүдэс дээж авах	Жилд 2 удаа	25,000	100,000		

Усан орчин							
1	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага (Анионууд: Cl ⁻ , SO ₄ ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ⁻ , HCO ₃ ⁻ - Катионууд: Na ⁺ K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ , pH, EC, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт)	Унд ахуйд хэрэглэж байгаа уснаас	Жилд 2 удаа	33,000	66,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ, -MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга, -MNS5667-2:2001 Усны дээж. Дээж авах. 2-р хэсэг. Дээж авах аргачлалын заавар.
Нийт зардал					506,000		

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2024 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Байгаль орчны асуудлыг хариуцах ажилтанд хариуцуулж гүйцэтгүүлэх, хяналт тавин ажиллах.	-	+	+	+	Уурхайн удирдлага	БОМТ-г хариуцан гүйцэтгэх
2	Байгаль орчныг хамгаалах сургалтыг ажилчдад зохион байгуулах	Үйл ажиллагааны зардалд орсон		+		Уурхайн удирдлага	

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” нэртэй
барилгын чулууны ордыг ашиглах төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2024

3	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	17*50,000 = 850,000	+	+	+	Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
4	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хамтран ажиллах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
Нийт зардал		850,000					

6.10.Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

"Шинэ зууны эхэн" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 16. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Өмнөговь аймаг байгаль орчны газар	Уулзалт, санал асуулга, тайлан хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	11-р сарын 01-ний дотор	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн удирдлага, байгаль орчны мэргэжилтэн	Уурхайд
2	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Тайлан хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлан, орон нутгийн дүгнэлт	12-р сарын 30-ны дотор			БОАЖЯ-ны ХБОБНУГ-т
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Танилцуулж тайлагнах	БОМТ-ний тайлан болон БОМТ-ий хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард			Засаг даргын тамгын газарт
	Нийт				-		

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Шинэ зууны эхэн” ХХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2024 онд БОМТ-нд нийт **11,416,000** сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 17. 2024 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2024 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	750,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	6,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,150,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,160,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	850,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	506,000
Нийт дүн		11,416,000

ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Шинэ зууны эхэн” ХХК-ийн “Эхэн” нэртэй барилгын чулууны ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“Шинэ зууны эхэн” ХХК-ийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Эхэн” барилгын чулууны ордын БОМТ-нд 2024 онд нийт **11,416,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“Шинэ зууны эхэн” ХХК нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал, 2014 он
7. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2022 он
8. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутагт орших “Эхэн” барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2023 он
9. <http://www.legalinfo.mn//>